



**НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
2 ДУГААР ХОРООНЫ ЗАСАГ ДАРГА**

С.Чоймболын гудамж, 2 дугаар хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15171
Утас: (976) 7011 0752
Цахил шуудан: 2.khoroо@chingeltei.gov.mn


2025.12.22 № 122
танай _____ -ны № _____ -т

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН
ХЭЛТЭСТ**

Соёлын биет бус өвийг үндэсний болон дэлхийн хэмжээнд сурталчлан алдаршуулах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан нэг өвлөн уламжлагчид мөнгөн шагнал олгох журмын 2.2.3.-т заасан баримт бичгийн дагуу хорооны иргэн соёлын биет бус өв тээгч Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, Монгол Улсын Уран хатгамалч Задь овогтой Цэнгэлсайханыг мөнгөн шагналд уламжлан, тодорхойлолтыг хавсралтаар хүргүүлж байна.

1 дүгээр хавсралт: Соёлын өв тээгчийн тодорхойлолт, 4 хуудастай.

2 дугаар хавсралт: Монгол бичгийн хавсралт, 1 хуудастай.

ЗАСАГ ДАРГА  Ц.БУЯНТОГТОХ





ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН 2 ДУГААР ХОРООНЫ ИРГЭН СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ ӨВЛӨН УЛАМЖЛАГЧ З.ЦЭНГЭЛСАЙХАНЫ ТОДОРХОЙЛОЛТ

2025.12.19.

Улаанбаатар хот

Задийн Цэнгэлсайхан нь 1956 онд Баянхонгор аймгийн Баянцагаан сумд төрсөн, хүүхдийн болон чих хамар хоолойн эмчийн мэргэжилтэй, Анагаах ухааны болон Төрийн удирдлагын магистр, Төрийн захиргааны Эрхэлсэн түшмэлийн тэргүүн зэрэгтэй, Монгол Улсын Соёлын Гавьяат зүтгэлтэн, биет бус өвийн үндэсний шилдэг, билэг авьяаст өвлөн уламжлагч, Уран хатгамалч хүн.

Тэр одоо 2005 онд өөрөө санаачилан байгуулсан Монголын Үндэсний Уламжлалт Уран хатгамалчдын холбоо НҮТББ-ын гүйцэтгэх захирлаар ажилладаг.

Түүний хүн ардыг соён гэгээрүүлэх, Монгол үндэснийхээ соёлын биет болон биет бус өвийг сэргээн хөгжүүлэх талаар 36 жилийн турш эх оронч, хүмүүнлэг үзэл бодлынхоо үүднээс сайн дурын үндсэн дээр санаачилан хийсэн ажил, гаргасан амжилт, үр дүн, урлан бүтээсэн бүтээлүүдийг нь харгалзан үзээд түүнийг Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 354 дүгээр тогтоолоор батлагдсан “Соёлын биет бус өвийг үндэсний болон дэлхийн хэмжээнд сурталчлан алдаршуулах, дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан өвлөн уламжлагчид мөнгөн шагнал олгох журам”-ын бүх шаардлагыг бүрэн хангасан хэмээн үзэж, тус шагналд тодорхойлж байна.

Тэр энэ чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажил, түүнд зарцуулсан цаг хугацааныхаа 80 илүү хувийг уламжлалт уран хатгамал, зээгт наамал, зоос ширээний сүлжмэлийн урлалын соёлын биет бус өвийг судлах, дотоод гадаадад сурталчлан таниулах, өвлүүлэн зааж сургах, уламжлалт загвар, урлах арга технологийг сэргээн хөгжүүлэх, орчин үеийн хэрэглээний шинэ загваруудыг зохион бүтээж хэрэглээнд нэвтрүүлэх, урлах шинэ арга технологи, загвар зохион бүтээх, урлаачдыг дэмжиж хөгжүүлэх, уг соёлын өвийн хүний хийгээд нийгмийн хөгжилд үзүүлж буй эерэг нөлөөллийг олж харж, олон нийтэд ойлгуулах, амьдралд бодитоор харуулж нотлох, манлайлан дагуулах, энэ талаар гарсан төрийн бодлого шийдвэрийг сурталчлан хэрэгжүүлэх зэрэгт зарцуулснаар мартагдах хэмжээнд хүрч байсан дээрх соёлын гайхамшигт өвүүдийг үндэсний хэмжээнд сэргээн хөгжүүлэх, Монгол үндэснийхээ соёлын өвийн гайхамшигийг дэлхийн түвшинд сурталчлан таниулахад онцгой үүрэг гүйцэтгэж байгаа юм.

Энэ талаар хийсэн ажлын заримыг нь дараах байдлаар жишээ болгон дурдахад :

Уран хатгамлын зүү ороох болон загасан нуруу хатгах хатгамал, уламжлалт аргаар хөөрөгний даалин урлах урлалыг 1987 оноос өдгөө хүртэл 18000 гаруй, зоос ширээний сүлжмэлийн урлалыг 200 гаруй, зээгт наамлыг 20 гаруй хүнд биечлэн зааж сургасны дээр өөрийн шавь нараараа дамжуулан Дорнод, Ховд, Завхан, Орхон аймгуудад холбооныхоо салбар, Дархан-Уул, Дорноговь, Баянхонгор, Өмнөговь,

Хэнтий, Улаанбаатар хотын дүүргүүдэд байнгын ажиллагаатай сургалтын төвүүд байгуулан өвлүүлэн сургах ажлыг эрчимтэй явуулж байна.

Өөрийн санаачилгаар 2005, 2010, 2018, 2023 онуудад БСШУЯ, Соёлын өвийн үндэсний төв болон бусад төрийн болон ТББ- уудтай хамтран Уран хатгамалчдын Улсын 4 удаагийн уралдааныг Дархан, Улаанбаатар хотуудад, 2023 онд “Хайр хүндэтгэлийн урлал” сэдэвт Уран хатгамалчдын үндэсний Анхдугаар чуулганыг Төрийн ордонд, 2017 онд “Хатгамаллах урлагийн гайхамшиг” нэртэй анхны дагнасан үзэсгэлэнг Богд хааны ордон музейтэй хамтран зохион байгуулж, урчуудыг дэмжин урамшуулж, 52 хүнд Монгол Улсын уран хатгамалч цол олгуулж, хоорондоо танилцаж, харилцан бие биенээсээ суралцах боломжийг олгосны дээр олон мянган үзэгчдийн идэвхи сонирхолыг татаж, ур чадварыг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн билээ.

Уран хатгамлын талаар дагнан хэвлэгдэж гарсан ном, гарын авлага бараг байхгүй байгааг харгалзан улс, орон нутгуудын музейд байгаа ховор нандин, хосгүй үнэт бүтээлүүд, өөрийн болон бусад нэрт урчуудын бүтээл, урлах арга зүй, гадаадын зарим орны хатгамалчдын бүтээлээс оролцуулсан “Уран хатгамал”, “Уран хатгамлын гайхамшиг”, “Урлах эрдмээс суралцаарай”, “Хатгамаллах урлагийн гайхамшиг” нэртэй ном, гарын авлагуудыг 2005 оноос хойш 6 удаа хэвлүүлж, олны хүртээл болгосны дээр бүх аймгууд, дүүргүүд, зарим аймгийн сумдуудын Эмэгтэйчүүдийн зөвлөлүүд, өөрийн салбаруудад үнэ төлбөргүйгээр олгож, үндэсний хэмжээнд сургалт явуулж буй бүх цэгийг сургалтын гарын авлагатай болгож хамтран ажиллаж байна.

Хатгамалтай эдлэлийн хэрэглээ болон гадаад дотоод зах зээлд борлуулалтыг нь өргөжүүлэх замаар охид, эмэгтэйчүүдийн ажлын байр, өрхийн орлогыг нь нэмэгдүүлэх зорилгоор зүү ороосон хатгамалтай орчин үеийн өргөн хэрэглээний 40 гаруй загвар зохион бүтээж, Оюуны өмчийн газраар патентжуулан үйлдвэрлэл, хэрэглээнд нэвтрүүлж олон мянган хүнийг байнгын болон нэмэгдэл орлоготой болгон хамтран ажиллаж байгаа юм.

Мөн үүнийг лавшруулан зүү ороох хатгамал болон зоос ширээний сүлжмэлийн урлалын уламжлалт арга технологийг баяжуулан урьд нь хэрэглэж байгаагүй 12 төрлийн шинэ аргачлал зохион бүтээж, зохиогчийн эрхээр баталгаажуулан сургалтандаа хэрэглэж эхэлсэн.

Монгол үндэснийхээ энэхүү соёлын биет бус өвүүдийг сурч, судалж, өвлүүлэх ажлын явцдаа түүнийг зөвхөн Монгол хүний оюун ухаанаар бүтээгдсэн болохыг олж тогтоосны үндсэн дээр тэдгээрийг ЮНЕСКО-гийн хүн төрөлхтний биет бус соёлын өвийн төлөөллийн жагсаалтад бүртгүүлэх санаачилгыг 2010 онд гаргаж, БСШУЯ, Соёлын өвийн үндэсний төвийн дэмжлэг авч, ажлын хэсгийн ахлагчаар ажиллан холбогдох баримт бичгийг боловсруулан, баримтат кино, фото зургийн цомгийг зааврын дагуу бүрдүүлж, БСШУ-ны сайдын гарын үсгээр баталгаажуулан ЮНЕСКО-д хүргүүлсэн бөгөөд цаашид бодит ажил болгохоор идэвхитэй ажиллаж байна.

3.Цэнгэлсайхан нь төрийн албанд удаан жил ажилласан ахмад ажилтан учраас өөрийн уран бүтээлийн болон олон нийтийн төлөөх ажлаа төрийн бодлого шийдвэр, үйл ажиллагаатай уялдуулан хамтатган холбож, шавь нар, харилцагчид, сонирхогчиддоо эх оронч, төр улсаа дээдлэх үзлийг төлөвшүүлэхийг ямагт эрмэлзэж байдгаараа онцлогтой. Жишээлбэл:

Түүний уран бүтээлийн дотроос “Миний эх орон мөнхөд мандан бадраг” сэдвийн хүрээнд бүтээгдсэн 18 цуврал бүтээлийг /Монгол Улсын тусгаар тогтнолын баталгаа болон төрийн бэлгэдийн цомог 2 бүтээл, Чингис хааны хөрөг, Монгол төрийн “Хүндэтгэлийн даалин”, “Тангараг”, “Мөхөшгүй голомт”, “Төрийн сүлдний цомог”, “Төрийн далбаа”, “Хүннү костюм”... зэрэг/ хараад хүмүүс эх орноо бас энэ сайхан соёлын өвөө бишрэхгүй байхын аргагүй байдалд хүрдэг байна.

Мөн МУ-ын Засгийн газраас хүүхдийн “Авьяс” хөтөлбөр зарлагдахад ЕБС-ийн хүүхдийн дунд уран хатгамлын үзэсгэлэн-уралдаан зарлаж, гялгар уутны хэрэглээг хориглох шийдвэр гарахад “Хатгамалтай ахуйн тор”2-ны шинэ загвар зохион бүтээж, Төрийн далбааны шинэ стандарт батлагдахад түүний шинэ загвар гаргаж нэвтрүүлэх зэргээр тухайн бодлого шийдвэрийн ач холбогдлыг өргөж, олон нийтэд шинэлэг аргаар сурталчилж байх жишээтэй.

БСШУЯ, Соёлын өвийн үндэсний төвийн санал болгосноор урчуудын баг бүрдүүлж, хувийн зардлаараа 2015, 2017 онд Энэтхэг, 2017, 2018 онд Унгар улсад олон улсын урлагийн наадмуудад улсаа төлөөлж анхдагчаар оролцож, БНСУ-ын Соёлын өвийн болон Соёлын сангийн төлөөлөгчид, ЮНЕСКО-оос зохион байгуулсан удаагийн сургалтанд уран хатгамал, зоос ширээний сүлжмэлийн урлалаар үзүүлэх сургалт хийж Монгол соёлын өвийг сурталчилсны дээр өөрийн санаачилгаар Япон, Солонгос, АНУ, БНХАУ, Грек улсад үзэсгэлэнд оролцож, АНУ, Япон, БНСУ-ын уран хатгамлын байгууллагатай холбоо тогтоож, харилцан мэдээлэл солилцож хамтын ажиллагааг эхлүүлсэн нь хатгамалчдын ур чадварыг дээшлүүлэхэд нөлөө үзүүлж байна.

Түүнчлэн түүний санаачлан Дарханд анх эхлүүлж байсан “Цагаан сар” үзэсгэлэн худалдаа, “Гар урлалын брэнд бүтээгдэхүүн” үзэсгэлэн худалдаа, “Монгол хувцсаараа гоёцгооё” арга хэмжээнүүд нь орон нутагтаа тогтмолжоод зогсохгүй улсын хэмжээнд дэлгэрч, хүмүүсийн хүсэн хүлээдэг арга хэмжээ болсон.

Тэр Монгол уран хатгамлын урлалын урлах арга зүй, ач холбогдлын талаар үндэсний хэмжээний бүх телевиз, радио, зарим сонин сэтгүүл, цахим мэдээллийн сувгуудаар олон давтамжтай сурталчилсан нь үндэсний хэмжээнд сурах хүсэл эрмэлзлэлийг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлсний дээр АНУ, Япон, Австрали, Энэтхэг, Унгар, Хятад, ОХУ, Сингапур улсуудын хэвлэлээр сурталчлагдсан байна.

Хамгийн сүүлийн жишээ нь Монгол Улс Бүгд Найрамдах Сингапур Улстай дипломат харилцаа тогтоосны түүхт 50 жилийн ойг тэмдэглэх арга хэмжээний хүрээнд 2 орны соёлын өвийн бүтээлээр шуудангийн марк гаргахад түүний урласан “Аяганы уут” бүтээл шалгаран зураг нь хэвлэгдэн гарсан.

Монгол үндэснийхээ хатгамаллах урлагийн гайхамшигт соёлын өвийг хүүхэд залуучуудад өвлүүлэхийг илүү чухал хэмээн үзэж, 2019 онд Монголын Хүүхдийн Урлан бүтээх төв-д “Уламжлалт уран хатгамлын” ангийг санаачлан шинээр нээж, иж бүрэн тохижуулан өгч, зөвлөн тусалж байгаа бөгөөд удам дамжсан өвлөгч болох өөрийн охин С.Ганцэцэгээр багшлуулан 2 жилийн хугацаанд 400 гаруй хүүхдэд зааж сургаж байгаагаас 8 хүүхэд гадаад орны Элчин сайдын яамдаас зарласан уралдаанд байр эзлэн шагнуулсны дээр тус дугуйлангийн 2 сурагч 2021 онд их сургуулийн дизайнерийн ангид урилгаар суралцахаар болжээ.

Тэр Энэхүү гайхамшигт соёлын өвийг хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах үйл ажиллагаагаа илүү үр дүнд хүргэхийн тулд 2005 онд Дархан хотын Эмэгтэйчүүдийн ордонд анх уран хатгамлын сургалтын танхим-урлан байгуулж, 2013 оноос өргөжүүлэн Монголын эмэгтэйчүүдийн Холбооны байранд шилжүүлэн ажиллуулж байсан бөгөөд энэ оны 4-р сараас Нийслэлийн Соёлын төв өргөөнд улам өргөжүүлэн бүрэн тохижуулж нээгээд ажиллаж байна.

3.Цэнгэлсайхан нь цаашид Монгол үндэснийхээ уламжлалт уран хатгамлыг ЮНЕСКО-гийн хүн төрөлхтний биет бус соёлын өвийн төлөөллийн жагсаалтад бүртгүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажлаа үргэлжлүүлэх, уран хатгамлын данасан музей байгуулах зорилго тавин ажиллаж байна .

Иймээс 3.Цэнгэлсайханыг соёлын биет бус өвийг үндэсний болон дэлхийн хэмжээнд сурталчлан таниулах, дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан өвлөн уламжлагчид олгодог шагналаар шагнуулахаар тодорхойлж байна .

3.Цэнгэлсайханы “Соёлын биет бус өвийг үндэсний болон дэлхийн хэмжээнд сурталчлан алдаршуулах, дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан өвлөн уламжлагчид мөнгөн шагнал олгох журам”-ын бүх шаардлагыг хангасан байдлын нотлох баримтыг заалт нэг бүрээр нь тайлбар болон зургаар харуулан хавсралтаар хүргүүллээ.

ТОДОРХОЙЛОЛТ БИЧСЭН:
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ХОЁРДУГААР
ХОРООНЫ ЗАСАГ ДАРГА



Ч. БУЯНТОГТОХ

 **МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ҮНЭМЛЭХ**
CITIZEN IDENTITY CARD OF MONGOLIA

Овог Family name
Бөх Цоохор
Bukh tsookhor

Эцэг/эх/-ийн нэр Surname
Зэдь
Zadi

Нар Given name
ЦЭНГЭЛСАЙХАН
TSENDELSAIKHAN

Хүйс Sex
Эмэгтэй / Female

Төрсөн он, сар, өдөр
Date of birth
1956/02/05

Регистрийн дугаар Registration number
TJ56020501 / TJ56020501



 **Олгосон байгууллага Issuing authority**
Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар
The General Authority for State Registration

Олгосон он, сар, өдөр Date of issue
2018/12/04

Хүчинтэй хугацаа Date of expiry
0000/00/00

Хаяг Address
УБ, Чингэлтэй, 2-р хороо
60 мянгат гудамж
21 байр, 29 тоот





- **1. үндэсний болон олон улсын хэмжээнд зохион байгуулагдсан уралдаан, тэмцээнд амжилт гаргасан талаар**
-



Үндэсний хэмжээнд 1991 онд зохион байгуулагдсан Ардын урлагийн их наадамд Хөөрөгний даалин, аяганы уутны хослолоор, 2011 оны Их наадамд “ Миний эх орон мөнхөд мандан бадраг” сэдэвт Монгол төрийн бэлгэдэл, тусгаар тогтнолын баталгааны бэлгэ тэмдгийн цомог бүтээлээр тус тус оролцож, Хүндэт үнэмлэх, “Хүрэл Од” медаль тус тус хүртсэн



"Миний эх орон мөнхөд мандан бадраг" нэртэй Монгол улсын тусгаар тогтнол, төрийн бэлгэдлийн цомог хатгамал бүтээл.
Хэмжээ: 90 x 120см 2010 он

Монгол хүмүүн
Ярихын түрүүнд
Дуулж хэлд ордог
Явахын түрүүнд
Бүжиглэж хэлд ордог

Дугаар...31...

3. Цэнгэлсайхан таныг

"АРДЫН УРЛАГИЙН
ИХ НААДАМ" - ЫН

хүрэл медаль хүртсэн тул
"Хүрэл од" медаль, үнэмлэх
олгов.

Соёл, урлагийн хороо,
Ардын урлагийн их наадмыг зохион
байгуулах хорооны

дарга Б. ЛХАГВАСҮРЭН

2011 оны 7 дугаар сарын 2-ны өдөр

3.Цэнгэлсайхан нь Монгол үндэсний уламжлалт соёлын өв болох уран хатгамалын төрлөөр үндэсний болон олон улсын чанартай олон уралдаан тэмцээнд оролцож, амжилт гаргаж шагнагдаж байсан. Үүнээс төлөөлөл болгож дурдвал:

2005 онд НҮБ-аас 2005 оныг Дэлхийн бичил бизнесийн жил болгон зарласан уралдаанд өөрийн зохион бүтээсэн зүү ороох хатгамалтай жижиг эдлэлээр оролцож, “Экспортлогдох боломж ихтэй бүтээгдэхүүн” номинацын тэргүүн байрын шагнал хүртэж байсан. /шинэ загварын патенттай бүтээгдэхүүний төлөөлөл/



Монголын гайхамшигт соёлын өв болох зүү ороох хатгамлаар чимэглэсэн орчин үеийн өргөн хэрэглээний 30 гаруй загвар зохион бүтээж, оюуны өмчийн гэрчилгээ авсан



2001 онд Үндэсний хэмжээнд зохион байгуулагдсан “Гар урлал 2001” уралдаант үзэсгэлэнд оролцон шалгарч, 2001 онд Япон улсын Токио хотод зохион байгуулагдах Монголын Экспортын барааны үзэсгэлэнд оролцох эрхээр шагнуулан мөн оны 10-р сард тус “Made in Mongolia” үзэсгэлэн худалдаанд амжилттай оролцож, Монгол үндэснийхээ уламжлалт уран хатгамлын соёлын өвийг сурталчлан таниулж, үнийн судалгаа хийж байв.



2010 онд Үндэсний хэмжээнд зохион байгуулагдсан Уран хатгамалчдын улсын 2-р уралдаанд “ Миний эх орон мөнхөд мандан бадраг” сэдэвт Монгол төрийн бэлгэдэл, тусгаар тогтнолын баталгааны бэлгэ тэмдгийн цомог 2 дахь бүтээлээрээ оролцож, Монгол Улсын уран хатгамалч цол өргөмжлөлөөр шагнагдсан



“Миний эх орон мөнхөд мандан бадраг” нэртэн 2 дахь цомог бүтээл.
2010 он. Хэмжээ: 105 x135 см

Урлалын хувьд, Төрийн дурлал болон тухайн хэсэг хэргийн болон давхар зүү орох катгмалар бүсэд 13 төрлийн катгмал, заагт нэмэлт, зоосон ширээний урлагийг хослуулснаар соёлын өвийн гайхэмшигтай гурвал чухал төрлийг хослуулсан бүтээлдээ утгаар энгэргүй бүтээл болсон юм.

2018 онд “Нүүдэлчин Монгол” Соёлын биет бус өвийн их наадамд өөрийн олон төрлийн хатгамалтай бүтээлүүдээрээ оролцож, МУ –ын Соёлын тэргүүний ажилтан цол тэмдэг, “Хамгийн олон шавь сургасан өвлөн уламжлагч” өргөмжлөлөөр шагнагдаж, Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчаар батламжлагдсан.




2022 онд үндэсний хэмжээнд зохион байгуулагдсан “Гар урлалыг дэмжин хөгжүүлэх боломж, шийдэл-2022” үзэсгэлэн форумд өөрийн урласан 1911- 1992 онуудад батлагдсан Монгол Улсын Төрийн сүлдний цомог хатгамал бүтээлүүд болон панелистаар оролцож, 1000 гаруй уран бүтээлчийн 3000 гаруй бүтээлээс шалгаруулсан “Шилдэг 100 бүтээл”-д охинтойгоо хамт шалгарч батламжлагдсан.



2022, 2025 онд зохион байгуулагдсан Нүүдэлчин дэлхийн фестивалуудад Нийслэлийн гар урлаачдыг шалгаруулах ажлыг хариуцаж, шалгарсан өвлөн уламжлагчдад зөвлөн тусалж, зохион байгуулан гэр үзэсгэлэн дэглэж оролцсон бөгөөд 2022 онд Гар урлалын баг багаараа болон түүний дотроос гэр урлаач Л.Бүрэнбаясах, Монгол хувцас урлаач Ж.Норжмаа нар хувиараа Тэргүүн байранд шалгарч шагнагдсан. 2025 онд нийт багаараа "Тэргүүн байранд шалгарч 100 сая төгрөгийн шагнал хүртсэний дотор гар урлалын багаас хатгамалчин өвлөн уламжлагч Ц.Батбуян, хатгамалчин Г.Чинбаяр, гэр урлаач Төмөрбат нар Шилдэг өвлөн уламжлагчаар шалгарч шагнагдсан амжилт гаргаж батламжлав. 2022 он





2025 оны 10-р сарын 10 12:38 PM

Өөрийн үнэлэмжээрээ бас нэг амжилт хэмээн үздэг зүйл бол Монгол Улс Бүгд Найрамдах Сингапур Улстай дипломат харилцаа тогтоосны түүхт 50 жилийн ойг тэмдэглэх арга хэмжээний хүрээнд Монгол шуудан компаниас 2 орны соёлын өвийн бүтээлээр шуудангийн марк гаргахаар зарласан шалгаруулалтад түүний урласан “Аяганы уут” бүтээл шалгарч, зураг нь уламжлалт соёлын өвийн онцгой нэг илэрхийлэл хэмээн зөвшөөрөгдөж, шуудангийн марк дээр хэвлэгдэн гарсан нь Монголдоо марканд хэвлэгдсэн анхдагч хатгамал бүтээл болсон юм.





**2. соёлын биет бус өвийг
сурталчлах, түгээн
дэлгэрүүлэх чиглэлээр
дотоод, гадаадад зохион
байгуулагдсан арга
хэмжээнд идэвхтэй
оролцсон талаар**



Монгол үндэсний уламжлалт гар урлалын соёлын өвийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр үндэсний хэмжээнд болон олон улсын чанартай дотоодод 2000 оноос хойш зохион байгуулалгдсан бараг бүх үзэсгэлэн, яармаг худалдаанд, Үндэсний их баяр наадам, цагаан сард зориулсан арга хэмжээнд 5 удаа хатгамаллах урлалын соёлын өвийг таниулах, сурталчлах, худалдаалах чиглэлээр оролцсон



Үргэлжлэл



-Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны яам, Соёлын өвийн үндэсний төвийн санал болгосноор 2015,2017,2018 онуудад Энэтхэг, Унгар улсуудад жил бүр зохион байгуулагддаг олон улсын Урлагийн наадмуудад 3-6 өвлөн уламжлагчдын баг бүрдүүлэн тус бүр 2 удаа оролцож, Монголынхоо соёлын өвийг сурталчилан таниулж, бас олон улсын урчуудаас суралцаж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна.



-Мөн дээрх болон бусад холбогдох төрийн байгууллагуудын хүсэлтээр Монголд айлчлан ирсэн гадаад / Япон, БНСУ, Унгар улс, ОХУ, Хятад / орны соёлын өвийн чиглэлээр ажилладаг байгууллагуудын төлөөлөгчдийг тусгайлан урландаа хүлээн авч Монгол урлалын гайхамшигт мөн чанар, ач холбогдлыг танилцуулж, сурталчилсан.



ЮНЕСКО-гийн үндэсний комисс болон Соёлын өвийн үндэсний төв, Монголын урлагийн зөвлөлөөс хамтран зохион байгуулсан 6 удаагийн сургалт, мэдээлэл, сурталчилгааны чанартай арга хэмжээнд уригдаж, сургалт хийх, лекц унших, танилцуулга хийх, кино контентод оролцох, үзэсгэлэн гаргах зэрэг байдлаар оролцсон



ЮНЕСКО-гийн Дэлхийн бүтээлч хотуудын сүлжээнд Нийслэл Улаанбаатар хот нэгдсэн батламж гардуулах ёслолд удмын 4 дөх үеийн өвлөн уламжлагч охин С.Ганцэцэг, 5 дахь үеийн өвлөн уламжлагч зээ охин Э.Мишээл нарын хамт өөрсдийн уран бүтээлийн дээжээс үзэсгэлэн гарган оролцож, гадаад дотоодын олон төлөөлөгчдөд соёлын өвийг танилцуулан сурталчилж, талархал илэрхийлэв.



Короногийн халдварын үед Соёлын яамнаас уриалж зохион байгуулсан "Цахим орчинд соёл түгээе Би хариуцлагатай иргэн" цувралд нэгдэж, 2020 онд лайваар сурталчилгаа хийж 300 мянга гаруй хүнд танилцуулсан .



СОЁЛЫН ЯАМ

Соёлын яамнаас уриалж буй
“Цахим ертөнцөд соёл түгээе!
БИ ХАРИУЦЛАГАТАЙ ИРГЭН” цувралд



Уран хатгамалч **З.ЦЭНГЭЛСАЙХАН** нэгдлээ.



СОЁЛЫН ЯАМ

ТАЛАРХАЛ

ХҮНДЭТ З.Цэнгэлсайхан ТАНАА

Монгол Улсын Соёлын Яамнаас цар тахлын хөл хорионы үед санаачлан хэрэгжүүлсэн “Цахим орчинд соёл түгээе! Би хариуцлагатай иргэн” уриалгад нэгдэн хүн ардынхаа бие сэтгэлийн дархлааг дэмжих ариун үйлсэд билиг авьяасаа зориулан идэвх санаачилгатайгаар хамтран ажилласан “Хариуцлагатай иргэн” танд уг “ТАЛАРХАЛ”-ын бичгийг гардуулж байна.

Энэхүү эрхэм үйлсэд нэгдэж, ур чадвар, урлаг соёлынхоо яндашгүй сайхнаар айл гэрлийн хойморт аз жаргал дуудаж, амар амгалангийн эгч болон морилсон Таны цаашдын уран бүтээлд улам их амжилт хүсье.

САЙД Сүхбаатар ЧУЛУУН

Улаанбаатар хот,
2020 оны 12 дугаар сарын 18

МОНГОЛЫН СОЁЛЫН ЯАМ



**3. өөрийн санаачилгаар
соёлын биет бус өвийг
сурталчлах, түгээн
дэлгэрүүлэх чиглэлээр
дотоод, гадаадад арга
хэмжээ зохион байгуулсан
талаар**



Уран хатгамлын зүү ороох болон загасан нуруу хатгах хатгамал, уламжлалт аргаар хөөрөгний даалин болон уламжлалт эдлэл хэрэглэлийг урлах соёлын өвийг 1987 оноос өдгөө хүртэл 18000 гаруй, үүний дотор АНУ, Япон, БНСУ зэрэг орнуудад ажиллаж амьдарч байгаа Монголчууд орсны дээр зоос ширээний сүлжмэлийн урлалыг 200 гаруй, зээгт наамлыг 30 гаруй хүнд биечлэн зааж сургаж, өөрийн шавь нараараа дамжуулан Дорнод, Ховд, Завхан, Орхон, Хөвсгөл аймгуудад холбооныхоо салбар, Дархан-Уул, Дорноговь, Баянхонгор, Өмнөговь, Хэнтий, Улаанбаатар хотын дүүргүүдэд байнгын ажиллагаатай сургалтын төвүүд байгуулах, сургагч багш нарыг бэлдэхэд нь туслан дэмжиж, өвлүүлэн сургах ажлыг эрчимтэй өргөжүүлэн явуулж байна.



Зоос ширээний сүлжмэлийн сургалт



Зээгт наамлын сургалт



Монгол үндэсний хувцас, Хөөрөгний даалингийн сургалтад суралцагсдын төлөөлөл

Хөөрөгний даалингийн сургалтад суралцагсдын төлөөлөл



2016 онд Хөдөлмөрийн яаманд санал тавьж, хөрөнгийн дэмжлэг авснаар 16 аймагт 40-60 хүнд хөөрөгний даалин болон Монгол хувцас урлах хосолмол сургалтыг зохион байгуулсан бөгөөд энд Баянхонгор аймгийн сургалтад оролцогчид байна .

Улс орныхоо ирээдүй болсон хүүхэд залуучуудад өвлүүлэн сургахыг чухалд үзэж Ид шидийн орны хүүхдүүдэд үнэ төлбөргүй сургалт явуулсны дээр Хүүхдийн урлан бүтээх төвд 2019 оноос Уламжлалт уран хатгамлын анги нээх санал тавьж, шийдвэрлүүлэн сургалтын танхимыг тохижуулан өгч, охин С.Ганцэцэгээр багшлуулан өдгөө 400 гаруй хүүхдэд зааж сургаад байна



Хүүхдийн урлан бүтээх төвд тохижуулсан танхим, сургалт



2012 онд Дархан-Уул аймагт анх удаа ЕБС-ын сургуулийн хүүхдүүдийн дунд уран хатгамлын үзэсгэлэн, олимпиад зохион байгуулав.



2025 оны 11 дүгээр сараас СУИС-тай хамтын ажиллагааг эхлүүлж, багш оюутнуудад сургалт явуулж эхлэв.

Өөрийн санаачилгаар 2005, 2010, 2018, 2023 онуудад Соёлын Яам, Соёлын өвийн үндэсний төв болон бусад төрийн болон ТББ- уудтай хамтран Уран хатгамалчдын Улсын 4 удаагийн уралдааныг Дархан, Улаанбаатар хотуудад, 2023 онд “Хайр хүндэтгэлийн урлал” сэдэвт Уран хатгамалчдын үндэсний Анхдугаар чуулганыг Төрийн ордонд, 2017 онд “Хатгамаллах урлагийн гайхамшиг “ нэртэй анхны дагнасан үзэсгэлэнг Богд хааны ордон музейд зохион байгуулж, урчуудыг дэмжин урамшуулж, 4 уралдаанаас шаларсан 52 хүнд Монгол Улсын уран хатгамалч цол олгож, хоорондоо танилцаж, харилцан бие биенээсээ суралцах боломжийг олгосны дээр олон мянган үзэгчдийн идэвхи сонирхолыг татаж, соёлын өвөө дээдлэх, өвөлж авах хандлага, ур чадварыг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн билээ.



Анхдугаар уралдаан 2005 онд Дархан хотын Эмэгтэйчүүдийн ордонд



Хоёрдугаар уралдаан 2010 онд Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейд



Гуравдугаар уралдаан 2018 онд Уран зургийн галерейд



Дөрөвдүгээр уралдаан 2023 онд Монголын Үндэсний музейд



Монгол үндэсний уламжлалт хатгамаллах урлалын соёлын өвийг хадгалан хамгаалах, өвлүүлэн уламжлуулах, түгээн дэлгэрүүлэх, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаарх төрийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор 2023 оны 11 дүгээр сарын 17-нд Уран хатгамалчдын үндэсний анхдугаар чуулганыг Төрийн ордонд зохион байгуулж, Монгол Үндэсний Уламжлалт Уран Хатгамалчдын Холбооны СТРАТЕГИ төлөвлөгөөний төсөл, “Соёлын өвийг хадгалан хамгаалах, өвлүүлэн уламжлуулах талаарх төрийн бодлого, түүний хэрэгжилт”, “Хатгамаллах урлагийн гайхамшиг”, Хатгамаллах урлалын соёлын өвийн талаар боловсролын хөтөлбөрт тусгах хэрэгцээ”, “Уран хатгамал-Соёлын бүтээлч үйлдвэрлэл” гэсэн илтгэлүүдийг хэлэлцээд, оролцогчид, урьдчилан судалгаанд хамрагдсан хатгамалчдаас гаргасан саналыг үндэслэн зөвлөмж гаргаж, Монгол Үндэсний Уламжлалт Уран Хатгамалчдын Холбооны СТРАТЕГИ-г баталсан.





Хүндэт ахан дуус та бүнийг
Гэр Хүүгийн Төвөөс захиан байгуул байгаа

"Монгол бахархал-4"

арга хэмээхэнд хүрээлэн ирээний урьж байна.

Зочин нутагчид:



МУ-ын уран хатгамалч
З.Цэнгэсэгийн
"Монгол эмэгтээнүүд
уран гартай, бурхан ухаантай."

★ ★ ★

МУСТА Б. Сэрчмаа
"Монголын үндэсний
уран нутарлалын гайхамшиг"



Есөн эрдэнийн эзэн спонсорууд:

Oakdale Rotary Club	Ж.Дамдинпилэ & Б.Оюунсүрэн
McKesson Н. Энхмэд	Б.Мянгарсүрэн & Ц.Байрагсүрэн
O Solongo	Хөдөөд хүү Н. Гантула
BM Б. Нарансүрэн	Нуука П.Одгончимал
Philanthropic Ventures Foundation	Сэр Франциска хот дахь МУ-ын ЕКГ
Б.Гарамсүрэн	Рейд нийн гэр бүл

Кранкер-ын гэр бүл

Уран нутарлалт • Үндэсний бүжиг • Мөрөн хуур

Хиймэл • Үндэсний хуудалдаа • Аамь сүлжээ

Такс : \$50 (хоол 1 дарс)

Хэзээ : 2017 оны 11 сарын 12, Нам гар, 5.30-8.30pm

Хаана : Би Монгол сургуулийн байр, 388 9th Street,
2nd floor, Oakland, CA

Утас : (510) 735-1810 Ариунтуяа,
(415) 632-2502 Батзориг, (510) 759-9229 Эска



2017 онд АНУ-ын Oaklandад уригдаж, Монголчуудаа Монголын гайхамшигт соёлын өв сэдвээр илтгэл тавьж, сургалт явуулав

Тэр Монгол уран хатгамлын урлалын урлах арга зүй, ач холбогдлын талаар үндэсний хэмжээний бүх телевиз, радио, зарим сонин сэтгүүл, цахим мэдээллийн сувгуудаар олон давтамжтай сурталчилсан нь үндэсний хэмжээнд сурах хүсэл эрмэлзлэлийг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлсний дээр АНУ, Япон, Австрали, Энэтхэг, Унгар, Хятад, ОХУ, Сингапур улсуудын хэвлэлээр сурталчлагдсан байна.






- **4. Соёлын биет бус өвийг
хамгаалах, хөгжүүлэх үйл
хэрэгт идэвхи
санаачлагатай оролцсон
талаар**
-



3.Цэнгэлсайхан нь 2005 онд анх санаачлан Уран хатгамалчдыг дэмжих “Эгнэшгүй санаа” төв НҮТББ-ыг байгуулж, Тэргүүнээр нь 2023 хүртэл хатгамалчид урчуудаа дэмжиж , хамтарч бүтээлчээр ажилласан бөгөөд 2023 онд охин С.Ганцэцэгийнхээ санаачлагыг дэмжиж, Монголын Үндэсний Уламжлалт Уран хатгамалчдын Холбоо болгон өргөжүүлэн өөрчилж, одоо Гүйцэтгэх захирлаар нь ажиллаж байна.



Соёлын биет бус өвийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэхэд байнгын ажиллагаатай, зөв байршилтай, чадварлаг сургагч багштай суралтын төв, урлан зайлшгүй хэрэгтэй учраас өөрийн санаачлагаараа 2008 онд Дархан хотын Эмэгтэйчүүдийн ордонд анхны урлан байгуулж, уран хатгамалтай үндэсний уламжлалт болон өргөн хэрэглээний жижиг эдлэл, гар хивс, Монгол хувцас хийх сургалтыг эхлүүлж, улмаар Улаанбаатар хотод шилжин суурьшаад 2014- 2019 онд Монголын эмэгтэйчүүдийн холбооны байранд, 2019- 2021 онд Хүүхдийн урлан бүтээх төвд, 2021-2025 онд HOBBY CENTER-т, 2025 оны 4 сараас Соёлын төв өргөөнд өргөжүүлэн иж бүрэнээр тохижуулан ажиллаж байна.



2008 онд анх байгуулсан урлан



Оршил төв 602 тоот МЭХолбооны байр 2014-2019он. HOBBY CENTER 11тоот 2021-2025 он



Хүүхдийн урлан бүтээх төвд тохижуулсан 2019-2021


Соёлын төв өргөөнд иж бүрэн засвар хийж, тохижуулан ажиллаж байгаа урлан



Орох хаалга, нүүдэлчний ахуйн соёл, монгол гэрийн чимэглэлийн хатгамалтай уламжлалт эдлэл хэрэглэлийг танилцуулан сурталчлах хэсэг



Номын сан, хатгамлын хэрэглэгдэхүүн, сургалтын үзүүлэн, үндэсний уламжлалт болон инноваци шингээж урласан эдлэл хэрэглэлийн загварууд, оюуны өмч, түүний баталгаа, гадаад орны хатгамлын загварууд, хатгамаллах урлалын соёлын өвийг танилцуулсан гадаад орны танилцуулга бүхий урлангийн үндсэн хэсэг.



Бидэнд үе дамжуулан өвлүүлж үлдээсэн удмын урчууд, тэдний хэрэглэж байсан үйл урлалын багаж хэрэгсэл, урласан эдлэлийн дурсамжит өв, гаргасан амжилтыг танилцуулах хэсэг






Өвлөн уламжлагчдад Эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилго бүхий Монгол улсын тусгаар тогтнол, мөнхөд хөгжин дэвшихийн бэлгэдлийг танилцуулах болон эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэхэд чиглэсэн галерейн хэсэг

Уран хатгамлын талаар дагнан хэвлэгдэж гарсан ном, гарын авлага бараг байхгүй байгааг харгалзан улс, орон нутгуудын музейд байгаа ховор нандин, хосгүй үнэт бүтээлүүд, өөрийн болон бусад нэрт урчуудын бүтээл, урлах арга зүй, гадаадын зарим орны хатгамалчдын бүтээлээс оролцуулсан “Уран хатгамал”, “Уран хатгамлын гайхамшиг”, “Урлах эрдмээс суралцаарай”, “Хатгамаллах урлагийн гайхамшиг” нэртэй ном, гарын авлагуудыг 2005 оноос хойш 7 удаа хэвлүүлж, олны хүртээл болгосны дээр бүх аймгууд, дүүргүүд, зарим аймгийн сумдуудын Эмэгтэйчүүдийн зөвлөлүүд, өөрийн салбаруудад үнэ төлбөргүйгээр олгож, үндэсний хэмжээнд сургалт явуулж буй бүх цэгийг сургалтын гарын авлагатай болгож хамтран ажиллаж байна.






Соёлын биет бус өвийг хамгаалах, хөгжүүлэх үйл хэрэгт өөрийн хувь нэмрээ оруулж, урлах уламжлалт арга технологи болон хэрэгээнд инноваци нэвтрүүлж, шүр сувдыг зүү ороох хатгамлаар хашиж, суурилж хатгах, зүү ороох хатгамлыг саагаар шаглаж хатгах болон зоос ширээний сүлжмэлийн уламжлалт арга технологийг баяжуулж, 3 ба 5 дагнаасаар сүлжих, тэдгээрийг голд нь хээ гаргаж сүлжих, бөөрөнхий сүлжих, түүнийг салаалж сүлжих зэрэг шинэ аргачлал гаргаж урлалд нэвтрүүлэн 12 төрлөөр зохиогчийн эрх авсан. Хатгамалтай эдлэлийн хэрэглээ болон гадаад дотоод зах зээлд борлуулалтыг нь өргөжүүлэх замаар охид, эмэгтэйчүүдийн ажлын байр, өрхийн орлогыг нь нэмэгдүүлэх зорилгоор зүү ороосон хатгамалтай орчин үеийн өргөн хэрэглээний 40 гаруй загвар зохион бүтээж, Оюуны өмчийн газраар патентжуулан үйлдвэрлэл, хэрэглээнд нэвтрүүлж олон мянган хүнийг байнгын болон нэмэгдэл орлоготой болгон хамтран ажиллаж байна.











Хүндэтгэлийн даалин

Богд хаан буюу тухайн үедээ Монгол Улсын төрийн тэргүүн байсан хүний барьж эдэлж байсан, **Монгол Улс мөнх орших, үеийн үед өөдлөн хөгжиж, мандан бадарч, хүн ард нь амар амгалан, аз жаргалаар бялхан байх төгс бэлгэдэл бүхий** даалинг загвар болгон сонгож, түүнийгээ дэлхийн дээд амжилтад тооцогдохуйц болгож, улс орныхоо мөнх оршиж, хөгжин дэвжиж, хүн зон нь зол жаргалтай байх ерөөлийг шингээж, харсан үзсэн бүхэн эерэг энерги авч, эх оронч байх сэтгэгдэл төрүүлдэг **УРАН БҮТЭЭЛ** болгохыг зорьж, хэмжээг нь 16 дахин томруулж, 5-9 дагнаасаар зүү ороож, 3 янзын загасан нуруу хатгаж, 4-40 утсаар сүлжсэн зоос ширээний 3 давхар сүлжмэлээр чимэглэн урласан. Хэмжээ нь 225х 85 см.

Зохиогчийн эрхтэй.




Зүү ороох хатгамлаар ямар ч нарийн зураг дүрсийг оёж болдгийг харуулах зорилгоор урлагийн бүтээл болгон урласан “Цагаан шүхэрт” бурхан. Зохиогчийн эрхтэй.



Монгол үндэсний хувцсыг зүү ороох хатгамлаар чимэглэх аргыг анх санаачлан дэлгэрүүлсэн



Гаанс, тамхины уут



Соёлын биет бус өвийг хамгаалах, хөгжүүлэх үйл хэрэгт хатгамалчдын идэвх, санаачлагыг дээшлүүлэхийн тулд өөрийн гэсэн урамшууллын тогтолцоо бий болгох санаачилга, загвар эскизийг гаргаж, УЗ-ийн хурлаар батлуулан хэвлүүлж, олгодог болсны дээр төрийн дээд болон Засгийн газрын шагналд тодорхойлох, гадаад, дотоод арга хэмжээнд урьж хамтарч оролцох зэргээр идэвхитэй ажиллаж байна .



Үндэсний болон олон улсын хэмжээний уралдаан, их наадамд оролцож, шагнагдсан, Уран хатгамалчдын улсын уралдааны тэргүүн байранд шалгарсан урчуудад хүртээдэг “Монгол Улсын Уран хатгамалч” цолны тэмдэг, түүнийг хүртсэн 52 хүний төлөөлөл



Уран хатгамалчдын улсын гуравдугаар уралдааны төрлүүдэд тэргүүн байранд шалгарч шагнагдсан “Монгол Улсын Уран хатгамалч” цолтнууд

3.Цэнгэлсайханы 18000 гаруй шавь нарын дотроос Дорноговь аймгийн Н.Нарантуяа олон улсын наадмаас “Өнгө зохицлын гайхамшиг” шагнал, Урантогос Дээлтэй Монгол 2024 наадмын шагнал, Завханы Мөнхтуяа 2022 оны Нүүдэлчин фестивалийн Шилдэг өвлөн уламжлагчийн шагнал, Н.Нарантуяа Төрийн дээд шагнал Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, Х.Даваахүү, Т.Цолмонсүрэн, С.Ганцэцэг, С.Цэцэгдэлгэр 3.Байгалмаа нар Соёлын Тэргүүний ажилтан цол тэмдэг, Х.Даваахүү, Болортуяа, Б. Мөнхтуяа, С.Цэцэгдэлгэр, С.Ганцэцэг, 3.Байгамаа, Т.Цолмонсүрэн, Д.Амарбаясгалан, С.Саранцэцэг, П.Бадамхорлоо, Н.Нарантуяа нар Уран хатгамлын Улсын уралдаанд тэргүүлж, МУ-ын Уран хатгамалч цол тэмдгээр, мөн 10 гаруй өвлөн уламжлагчид Ардын тэргүүний авьяастанаар тэмдгээр шагнагдсан.



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ
УЛАМЖЛАЛТ УРАН
ХАТГАМАЛЧДЫН ХОЛБОО



Олон улсын эрхийг хамгаалах
өдрийг тохиолдуулан
ӨВЛӨН УЛАМЖЛАГЧ ХАТГАМАЛЧ
огон медаль гардуулах бүртгэлийн
материалыг 2024.03.08-ны
өдөр хүртэл хүлээн авна.

Шагналыг
2024.03.08-ны өдрийн 13:00 цагаас
МҮҮҮХХ-ны байранд гардуулна.

Утас: 9409-0575

8
MARCH

HAPPY
Women's
Day



Мөн Соёлын өвийг уламжлан авч, 5 жилээс дээш хугацаанд уран бүтээл хийж, бусдад өвлүүлэ уламжлуулж байгаа урчуудад олгодог энэхүү тэмдгийг бий болгосон нь урчуудын урам зоригийг сэргээж хамтын ажиллагааг идэвхижүүлж байна.




2017.01.27- 02.08 Богд хааны ордон музейд түүний санаачлан зохион байгуулсан
“Хатгамаллах урлагийн гайхамшиг” уран хатгамлын анхдагч дагнасан үзэсгэлэн






Дархан-Уул аймгийн Засаг даргын дэмжлэгээр Анх удаа ЕБС-ын хүүхдүүдийн дунд уран хатгамлын уралдаант үзэсгэлэн худалдаа, олимпиад зохион байгуулав. 2013 он



Уламжлалт уран хатгамлыг ЮНЕСКО-гийн хүн төрөлхтний ББСӨ-ийн төлөөлөлийн жагсаалтад бүртгүүлэх материал бэлтгэх явц



Үндэсний уламжлалт уран хатгамлын үнэт соёлын өвийг дэлгэрүүлэх ажлынхаа хүрээнд “Хайраа шингээж урлая” аяныг 2017 оны 12 дугаар сарын 04-ний бэлэгт сайн өдрөөс эхлэн 6 сарын хугацаатай өрнүүлэн зарлаж байна.

Тус аяны хугацаанд Монгол суу ухааны үндэс, ундрага нь болсон гайхамшигт зүү ороох урлалаар өөрийн хамгийн сайхтай хүндээ ураа гаргаж, хайраа шингээж, ерөөл өргөж нэгэн сайхан эдлэл хэрэглэлийг урлаж, эдлэх эзэнд нь өдрийн сайныг сонгож, гүн хүндэтгэлтэйгээр гардуулна.

Энэхүү аянд оролцогчдод зохион байгуулагчдын зүгээс дараах дэмжлэг үзүүлнэ.

- Зүү ороох оёдлын сургалтыг үнэ төлбөргүй явуулах
- Урлах эдлэл, хэрэглэлийнх нь загвар эскизийг нь гаргаж өгөх
- Хүссэн загвараар нь бэлдэц захиалгаар хийж өгөх
- Үндсэн болон туслах материалыг захиалгаар хангах
- Урлах бүхий л хугацаанд үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх
- Захиалгаар угсарч, эцсийн бүтээл болгоход нь туслах
- Захиалгаар ерөөл шингээсэн бүтээл урлаж өгөх
- Урласан бүтээлд нь батламж олгох
- Гардуулах хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулах
- Шилдэг 10 бүтээл шалгаруулж, тусгайлан батламж олгох
- “Хайр шингээсэн урлалын үзэсгэлэн өдөрлөг” зохион байгуулах болно.

Монгол үндэсний өв соёлоо дээдлэгч хүн бүрийг энэхүү аяныг дэмжиж оролцохыг урьж байна.

Ерөнхий зохион байгуулагч :

Монголын Уран Хатгамалчдыг Дэмжих "Эгнэшгүй санаа" төв НҮТББ

Хамтран зохион байгуулагч:

Соёлын Өвийн Үндэсний төв

Монголын Эмэгтэйчүүдийн Холбоо

Нийгмийн Сайн Сайхны Төлөө "Гал голомт" Үндэсний Хөдөлгөөн



Монголын Уран Хатгамалчдыг Дэмжих

“Эгнэшгүй санаа” төв НҮТББ

Хаяг: БЗД 3-р хороо Оршил төв. 602 тоот

Харьцах утас: 99038896, 94090575

Facebook: Tsengelsaikhan Zadi, Gantsetseg Ser-Od

“Хайраа шингээж урлая” сэдэвт Үндэсний аяны зар мэдээ. 2017.12.06- 2018.06.01

3.Цэнгэлсайхан Хатгамлаллах урлалын соёлын өвийг хагжүүлэхийн төлөө 40-өөд жил ажиллахдаа уг ажлыг бусад гар урлал, Мухайн үеийн төрийн бодлого шийдвэртэй уялдуулах талаар санаачлалтай ажилладаг уламжлалтай.





2001 оноос Дархан-Уул аймагт анх санаачлан эхлүүлж байсан “Цагаан сар” үзэсгэлэн худалдаа нь өдгөө улс орон даяар зохион байгуулагддаг, иргэд олны хүсэн хүлээдэг арга хэмжээ болон дэлгэрсэн билээ.

МҮҮҮХХ нь сүүлийн 3 жил Дээлтэй Монгол наадамд зохион байгуулалттайгаар дэмжин оролцдог болж, гишүүд нь шилдгээр тодрох болов



2024.07.09

3.Цэнгэлсайхан нь 2007 онд АНУ ын Уран хатгамалчдын байгууллагын гишүүн болж 17 жилийн турш хамтран ажиллаж, түүний улирал тутамд гаргадаг NEEDLE ARTS сэтгүүлийг улирал тутамд хүлээн авч хатгамалчиддаа түүнээс суралцах боломжийг олгож байна





Тэр 2023 онд Европын холбооны Элчин сайдын яамаас зохион байгуулсан сургалтад хамрагдаж, Гар урлалын бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд гаргахад чанар стандартыг хэрхэн хангах, үйлдвэрлэлийн бүтээмжийг хэрхэн нэмэгдүүлэх, маркетингийн үр дүнтэй аргууд, сав баглаа боодлын чухал нөлөөлөл зэргээс суралцаж, хамт суралцагсдын баг бүрдүүлэн хамтран ажиллаж байна.

3.Цэнгэлсайханы Монгол үндэсний уламжлалт соёлын өвийг хадгалах, хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, эх орон хүн ард түмнийхээ хөгжил дэвшил, сайн сайхны төлөө 40 гаруй жил хүчин зүтгэж, гаргасан амжилтыг нь үнэлж, 2019 онд МУ-ын ЗГ-ын 475 дугаар тогтоолоор батлагдасан Соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөн эзэмшсэн “Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч” билэг авьяастны үндэсний жагсаалтад бүртгэж, 2021 онд МУ-ын Ерөнхийлөгчийн зарлигаар Соёлын Гавьяат зүтгэлтэн хэмээх алдрыг хүртээсэн



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 12 дугаар сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 475 ҮНДЭСНИЙ ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 13.1.8-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөн эзэмшсэн “Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалт”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Дээрх жагсаалтад орсон өвлөн уламжлагчид батламж олгох, алдаршуулах, урамшуулах, шавь сургалт зохион байгуулахад нь дэмжлэг үзүүлэх зохих арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ

Боловсрол, соёл, шинжлэх

ухаан, спортын сайд

Ё.БААТАРБИЛЭГ

**СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ ӨВЛӨН УЛАМЖЛАГЧИЙН
ҮНДЭСНИЙ ЖАГСААЛТ**

№	Билэг авьяастны нэр	Өвлөсөн өвийн төрөл	Төрсөн он	Үндсэн захиргаа (аймаг, сум, дүүрэг)
1. Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд				
5. Гар урлал				
1.	Самбуугийн Батболд	Шагайн харвааны зэмсэг урлал	1949	Архангай аймгийн Эрдэнэбулган сум
2.	Цэнддоогийн Батбуян	Зоосон ширээ	1959	Өмнөговь аймгийн Даланзадгад сум
3.	Гомбожавын Батбуян	Үндэсний бөхийн хэрэгсэл урлаач	1951	Төв аймгийн Сэргэлэн сум
4.	Дашзэвэгийн Гүндэгмаа	Хөхүүр урлах арга барил, Эсгий урлал, дах дэгтий, суран эдлэл	1957	Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сум
5.	Халтарын Дуламсүрэн	Уран хатгамал	1946	Дундговь аймгийн Дэлгэрцогт сум
6.	Лондоншаравын Дэмчиггарав	Хөгжим урлал	1950	Архангай аймгийн Эрдэнэбулган сум
7.	Нямбуугийн Ихтөр	Дархан	1958	Өмнөговь аймгийн Манлай сум
8.	Дамдины Пүрэв	Ходок тэрэг, Тэмээн хөсөг урлал	1969	Дорнод аймгийн Цагаан-Овоо сум
9.	Жаалын Пүрэв	Уран дархан	1937	Дундговь аймгийн Адаацаг сум
10.	Жамбаагийн Сүхбаатар	Нум, сумын урлал	1940	Дорнод аймгийн Халхгол сум
11.	Махбалын Төрбат	Мөнгөний дархан	1962	Улаанбаатар хот
12.	Должинсүрэнгийн Уламбаяр	Морин хуур урлаач	1963	Дорноговь аймгийн Сайншанд сум
13.	Цэдэнгийн Цагаан-Өвгөн	Сийлбэр	1933	Хэнтий аймгийн Мөрөн сум
14.	Задийн Цэнгэлсайхан	Уран хатгамал	1956	Баянхонгор аймгийн Баянцагаан сум
15.	Совдын Лувсанзундуй	Уран зураг	1928	Хэнтий аймаг



МОНГОЛ УЛС
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА

Наадамчдын зам 1200, Арцатын ам,
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот, 17100
Утас: (976-11) 32 39 77, 32 71 99
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2025. 12.30 № 01/8600

танай _____-ны № _____-т

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЗАХИРАЛ Г.ЭНХБАТ ТАНАА

“Соёлын биет бус өвийг үндэсний болон дэлхийн хэмжээнд сурталчлан алдаршуулах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан өвлөн уламжлагчид мөнгөн шагнал олгох тухай журам”-ын дагуу шалгуур үндэслэл хангаж буй өвлөн уламжлагчдын мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 1. хуудастай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Х.НЯМБААТАР

1725141030

یہ دیکھ کر ہر شخص حیرت میں رہ گیا



معلق من معلق من معلق و
معلق من معلق من ... معلق من

[illegible]

ۛ- . . نكسوسن



بندوبند من در سر صحنه (فصل دوم)
بمبئی و بنسبت من و من در سر صحنه

1725091434

Нийслэлийн Засаг даргын 2025 оны
...12... дүгээр сарын ...30...-ны өдрийн
...01/8600... дугаар албан бичгийн
хавсралт

ШАГНАЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ ӨВЛӨН
УЛАМЖЛАГЧДЫН НЭРС

Д/д	Дүүрэг	Нэр дэвшигчдийн тоо	Нэр дэвшигчийн мэдээлэл
1	Баянгол дүүрэг	6	Гүен Балданцэрэн /ГЮ47020919/
2			Хонгор Уртнасан /ПЭ56091001/
3			Баасанхүү Цэрэндагва /НЭ90020515/
4			Далхаа Эрдэнэзуу /УУ65011351/
5			Төмөрхүү Батмөнх /ЧП46021533/
6			Равжаа Санжсүрэн /ОЭ53091572/
7	Баянзүрх дүүрэг	2	Алтангэрэл Дагзмаа /РЭ51110901/
8			Эрдэнэцогт Баатаржав /УС72031617/
9	Налайх дүүрэг	1	Энхтуяа Хүрэлбаатар /ДП75031311/
10	Сонгинохайрхан дүүрэг	1	Дурма Балган /ОЭ60072973/
11	Сүхбаатар дүүрэг	1	Дэндэв Баярхуяг /ХН71051917/
12	Чингэлтэй дүүрэг	1	Задь Цэнгэлсайхан /ТЖ56020501/
13	Хан-Уул дүүрэг	1	Лхагвасүрэн Лхамрагчаа /ОЮ81040814/